

2023 оны гуравдугаар сар

○Нэр : ЗОРИГБАЯР ТАМИР

○Улс : Монгол

○Шалгалт өгсөн газар : Монгол

○Шалгалт өгсөн сэдэв : Япон хэл, Математик,  
нийгмийн ухаан

○Илсэх хүсэлтээ илгээсэн сургуулийн тоо : 2

※Миний элссэн хамтарсан хөтөлбөрт үндэсний 10 их,  
дээд сургуулийг хамтран ажилладаг  
сургуулиудаар консорциум байгуулж, шилжилтийн  
шалгалт хийсэн. Японы консорциумын 10 сургуулиас  
би Киотогийн Технологийн дээд сургууль,  
Тоёоо хашигийн Технологийн Их Сургуулийг сонгоод  
тэнцсэн.

○Төгссөн сургууль : У В С УЛААНГОМ ЦОГЦОЛБОР 1-Р  
СУРГУУЛЬ

○Тэтгэлэг авдаг эсэх : Авдаг

※Хамтарсан хөтөлбөр

## Ирэхээс өмнөх элсэлтийн системийг ашиг

### лан гадаадад суралцах тухай

#### ① Япон улсыг зорих болсон шалтгаан

Ахлах сургуульд байхад гадаадад суралцах хүсэлтэй байсан. Тэтгэлэгтэй гадаадад суралцах талаар бодож судлаж эхэлсэн. Тэр үед Япон, Монгол улсын засгийн газрын хамтарсан 1000 инженер төсөл 1 жилээр сунгагдсан. Инженер болох хүсэлтэй миний хувьд инженерчлэл хөгжиж байгаа Япон улсад суралцах боломж гарч ирсэн нь энэ төсөл байсан.

#### ② Суралцаж буй хот, сургууль зэрэгээ сонгох болсон шалгаан болон хэрхэн бэлдсэн талаар

Миний сонгосон Киото хот нь Японы эртний нийслэл

төдийгүй Япон хэв маягийг хадгалж үлдсэн хот болохоор японд байгаа мэдрэмжийг илүү их төрүүлдэг. Анимэд дуртай болохоор анимэ шиг бас тайтан, цэвэрхэн хот учраас сонгосон. Цагаарын хувьд зундаа тийм ч халуун биш, өвөлдөө хүйтэн биш. Мөн Киото хот нь үзэх газар олон учраас амралтаараа хол явалгүйгээр гоё газар үзэх боломжтой..



Бунхан дээр

### ③ Шалгалтандаа бэлдсэн миний арга барил

Монголд 2жил хагас Япон хэл сурсан. Сүүлийн 1жилд нь япон хэл дээр матетамик, физик, химийн хичээл судалсан. EJU-д бэлдэхдээ өнгөрсөн онуудын материал дээр ажиллаж чадахгүй байсан дасгалуудаа чаддаг болтлоо бэлдсэн. Миний хувьд математик физик тийм ч хэцүү байгаагүй ч хими япон хэл хэцүү байсан. Ялангуяа химийн элементийн нэр нэгдлийн нэргэх мэт зүйлсийг цээжлэх хэцүү байсан. EJU шалгалт ЭЕШ-ээс бага зэрэг хэцүү байсан чагууллага нь тийм зөрүүтэй байгаагүй.

### ④ Их сургуулийн хичээл болон оюутны амьдрал

Монголд 2жил хагас Япон хэл сурсан. Сүүлийн 1жилд нь япон хэл дээр матетамик, физик, химийн хичээл судалсан. EJU-д бэлдэхдээ өнгөрсөн онуудын материал дээр ажиллаж чадахгүй байсан дасгалуудаа чаддаг болтлоо бэлдсэн. Миний хувьд математик физик тийм ч хэцүү байгаагүй ч хими япон хэл хэцүү байсан. Ялангуяа химийн элементийн нэр нэгдлийн нэргэх мэт зүйлсийг цээжлэх хэцүү байсан. EJU шалгалт ЭЕШ-ээс

бага зэрэг хэцүү байсан чагууллага нь тийм зөрүүтэй байгаагүй.

**⑤ Монголоосоо Японы их дээд сургууль руу хүсэлтээ явуулах системийг ашигласаны давуу**

Ирэхээс өмнөх элсэх хүсэлт явуулахын давуу тал нь Японд ирсэнд аруйдаа элсэх боломжтой. Би ШУТИС-д сурч байхдаа энэ сургуульд элссэх хүсэлт, элсэлтийн шалгалт, бичиг баримтын илгээсэн. Энэ нь Японд гадаадад суралцах хүсэлтэй оюутнуудад боломж олгон гэж бодож байна. Хэрэв ирэхээс өмнөх элсэлтийн зөвшөөрлөө ашиглаагүй бол эхлээд Японд ирж, Японд суралцахаар шалгалт өгөөд дараа нь элсүүлж, тэнцсэн тохиолдолд элсэлт авна. Энэ нь олон улсын оюутнуудад маш хэцүү байдаг. Тиймээс ирэхээс өмнөх элсэлтийн зөвшөөрлийг ашиглах нь маш сайн хэрэг юм.

**⑥ Монголоосоо Японы их дээд сургууль руу хү**

Гадаадад суралцахын тулд ирэхээс өмнөх элсэлтийн явуулж байгаа хүмүүсийн хувьд хамгийн чухал зүйл бол EJU-ийн дүн юм. Тиймээс шалгалтанд бэлтгэх шаардлагатай. Шалгалтандаа өдөр бүр бэлдэх хэрэгтэй гэж бодож байна. Учир нь EJU шалгалт тийм ч амархан биш. Дараа нь та баримт бичгийг явуулахдаа өөрийн давуу талыг зөв бичих хэрэгтэй гэж бодож байна. Эцэст нь танд англи хэлний оноо хэрэгтэй байгаа тул Японд TOEIC гэх шалгалтын оноо шаарддаг тул шалгалтыг өгсөн нь дээр гэж бодож байна.